



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨААТҮГ-ЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/44/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "ЦЭБЭ Консалтинг аудит" ХХК-
ийн Захирал: Д.Энхбаатар
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Улаанбаатар хот

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
4. Аудитын тайлан	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. Аудитын илрүүлэлт	16
5.1 Албан шаардлага.....	17
5.2 Зөвлөмж.....	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	18
6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Т.ПҮРЭВХАТАН ТАНАА

2025.03.17 № 07/1032
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, хараат бусаар, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь аж ахуйн нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийн QR кодтой лавлагааг программчилж, Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим системийн "Тусгай зөвшөөрөл-Лавлагаа", "Зөвлөх үйлчилгээ-Иргэн, хуулийн этгээд" цэсэд байршуулан ашиглалтад оруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжиж буй орон нутагт 431, хоног 115, нийт 546 төсөл, арга хэмжээнд, гадаадын зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр нийт 26 төсөл, арга хэмжээнд барилгын норм, дүрэм, стандартын дагуу захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн байна.

ТӨБЗГ-ын даргын 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 207 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд ашиглалтад хүлээлгэн өгсөн Замын-Үүд хилийн боомтын барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лаборатори байгуулах ажлын хүрээнд бий болсон 7 нэрийн 2,621.7 сая төгрөгийн барилга, байгууламж, 35 нэр төрлийн 235 ширхэг 235.5 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 8 нэр төрлийн 17 ширхэг 60.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 2,917.8 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 223, 546 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 28 нэр төрлийн 171 ширхэг 2,428.3 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэснийг санхүүгийн тайланд толилуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 703 тоот тогтоолоор тус төвийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсныг 2024 оны 546 тоот тогтоолоор анх батлагдсан нийт орлогыг 13,390.3 сая төгрөг, нийт зардлыг 12,148.5 сая төгрөг, цэвэр ашгийг 1,113.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтыг 2,237.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 28,959.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 24,577.6 сая төгрөгийн зардал гарган, төлөвлөсөн ашгийг 2,279.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3,924.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудал

Тус төвийн санхүүгийн тайланд Барилга хот, байгуулалтын сайдын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" тушаалаар батлагдсан Барилга байгууламжийн норм, нормативын сангийн данс тусгагдсан байна. Энэхүү сан нь Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.7, 5.8 дахь хэсгийг хэрэгжүүлж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн судалгаа хийх, боловсронгуй болгох, өөрийн орны нөхцөлд тохирсон үндэсний норм, нормативын баримт бичгийг боловсруулах, батлуулах болон хэвлүүлэх, сурталчлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах үйл ажиллагааг зохицуулах зорилготой байна.

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ТӨБЗГ-ын 2018 оны 85 дугаар тогтоолоор баталсан дүрмийн 4.4.1.12-т заасан чиг үүргийн хүрээнд барилгын гол 13 төрлийн 79 нэрийн материалын үнийн мэдээллийг гарган "Барилгын мэдээллийн эмхэтгэл" сэтгүүл, mcis.gov.mn, Барилга.мн сайтуудад нийтэлж иргэн, аж ахуйн нэгжийг мэдээ мэдээллээр ханган ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26,419,701,172.81	34,456,517,306.17
1.1.2	Дансны авлага	98,807,415.42	2,480,425,801.70
1.1.4	Бусад авлага	120,522,000.00	121,500,000.00
1.1.6	Бараа материал	399,104,942.97	309,698,327.99
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,038,135,531.20	37,368,141,435.86
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,867,023,782.94	10,052,427,544.26
1.2.2	Биет бус хөрөнгө	1,297,934,006.54	1,381,842,299.03
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,164,957,789.48	11,434,269,843.29
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34,203,093,320.68	48,802,411,279.15
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,531,712,418.33	5,867,738,662.77
2.1.1.3	Татварын өр	75,724,323.57	441,347,173.23
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	12,599,609,034.53	21,714,403,931.69
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,394,156,486.40	1,632,308,822.78
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	18,601,202,262.83	29,655,798,590.47
2.2	Өр төлбөрийн нийт дүн	18,601,202,262.83	29,655,798,590.47
2.3	Эздийн өмч		
2.3.2	Өмч: – төрийн	8,159,338.00	8,159,338.00
2.3.4	Нэмж төлөгдсөн капитал	195,479,515.00	195,479,515.00
2.3.7	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,337,339,884.99	1,337,339,884.99
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,454,791,998.45	6,454,791,998.45
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	7,606,120,321.41	11,150,841,952.24
2.3.11	Эздийн өмчийн дүн	15,601,891,057.85	19,146,612,688.68
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	34,203,093,320.68	48,802,411,279.15

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	13,373,467,744.97	25,825,141,892.50
2	Борлуулалтын өртөг	88,139,814.32	175,604,215.03
3	Нийт ашиг (алдагдал)	13,285,327,930.65	25,649,537,677.47
5	Хүүний орлого	473,987,346.36	3,134,293,072.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	12,530,465,450.46	24,401,984,367.22
12	Бусад зардал	3,400,000.00	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	7,289,619.76	(4,080,993.53)

Барилга хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	108,773,806.00	(17,256,155.01)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,341,513,252.31	4,360,509,234.26
19	Орлогын татварын зардал	75,724,323.57	436,050,923.43
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,265,788,928.74	3,924,458,310.83
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,265,788,928.74	3,924,458,310.83
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	1,265,788,928.74	3,924,458,310.83

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний дүн	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	6,791,896,742.67	14,787,667,479.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(451,565,350.00)	(451,565,350.00)
Залруулсан үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	6,340,331,392.67	14,336,102,129.11
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	1,265,788,928.74	1,265,788,928.74
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	7,606,120,321.41	15,601,891,057.85
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	7,606,120,321.41	15,601,891,057.85
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	3,924,458,310.83	3,924,458,310.83
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	379,736,680.00	379,736,680.00
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,159,338.00	195,479,515.00	1,337,339,884.99	6,454,791,998.45	11,150,841,952.24	19,146,612,688.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	28,230,364,350.51	50,445,498,562.94
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого	23,535,913,343.85	47,776,916,464.91
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,694,451,006.66	2,668,582,098.03
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,636,284,882.73	42,094,209,311.74
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	6,029,788,104.53	10,598,235,003.71
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,700,895,675.50	3,550,939,555.71

Барилга хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,785,044,678.90	1,322,827,865.06
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	84,703,059.45	130,139,668.85
1.2.5	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,326,027,330.53	453,291,072.88
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,295,155,212.01	2,376,036,289.91
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	13,098,630.84	26,891,952.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	9,401,572,190.97	23,635,847,903.62
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,594,079,467.78	8,351,289,251.20
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	525,879,562.80	1,979,663,904.69
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	525,879,562.80	1,979,663,904.69
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	975,383,642.00	2,290,056,029.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	975,383,642.00	2,074,310,029.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	215,746,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(449,504,079.20)	(310,392,124.31)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	=	=
3.4	Валютын ханшийн зөрүү	7,289,619.76	(4,080,993.53)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,151,865,008.34	8,036,816,133.36
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,267,836,164.17	26,419,701,172.81
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,419,701,172.81	34,456,517,306.17

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2023 он	2024 он		Зөрүү	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт борлуулалт					
1.1	Захиалагчийн хяналтын орлого	7,640,222.4	20,910,610.13	18,809,445.2	2,101,164.9	90.0
1.2	Нормчлолтой холбоотой орлого	626,791.6	738,798.7	1,196,097.5	(457,298.8)	161.9
1.3	Инженер техникийн ажилтны сургалтын орлого	412,325.6	600,000.00	652,638.2	(52,638.2)	108.8
1.4	Бүтээгдэхүүн баталгаажуулалтын орлого	97,366.2	110,000.0	105,956.9	4,043.1	96.3
1.5	Зураг төсөл, магадлалын орлого	2,679,621.6	2,960,852.1	4,246,502.9	(1,285,650.7)	143.4

Барилга хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

1.6	Лабораторийн орлого	572,472.3	602,026.3	564,401.1	37,625.2	93.8
1.7	Бусад орлого (БАЖ, ХАБЭАхуйн дэвтэр, хүүгийн орлого)	1,818,655.5	2,624,865.0	3,384,393.2	(759,528.2)	128.9
1.8	Нийт орлого	13,847,455.1	28,547,152.3	28,959,435.0	(412,282.7)	101.4
	Үүнээс: Цэвэр борлуулалт	13,759,315.3	28,446,652.3	28,783,830.7	(337,178.5)	101.4
2	Нийт зардал	12,618,605.3	26,714,449.3	24,577,588.6	2,136,860.8	92.0
	Үүнээс: Удирдлагын зардал	481,084.8	827,641.8	674,753.3	152,888.5	81.5
3	Үйл ажиллагааны бус зардал	3,400.0	5,000.00	-	5,000.0	-
4	Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	7,289.6	-	4,081.0	(4,081.0)	-
5	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	108,773.8	-	17,256.2	17,256.2	-
6	Татварын өмнөх ашиг	1,341,513.3	1,827,702.9	4,360,509.2	(2,532,806.3)	238.6
7	Цэвэр ашиг (алдагдал)	1,265,789.0	1,644,932.6	3,924,458.3	(2,279,525.7)	238.6
8	Төсвийн төлбөрт нийт дүн	3,862,246.1	6,400,847.9	5,953,242.8	447,605.1	93.0
	а/ Орлогын татварт	75,724.3	182,770.3	436,050.9	(253,280.6)	238.6
	б/ НДШимтгэл	2,614,600.6	4,297,631.5	3,546,430.0	751,201.4	82.5
	в/ Хувь хүний орлогын албан татвар	1,121,988.1	1,818,281.1	1,883,937.5	(65,656.4)	103.6
	г/ Бусад татварт (газрын төлбөр, даатгал, ХХ-ээс суутгасан ОАТ, тээврийн хэрэгслийн татварт, ҮХХАТ)	49,933.1	102,165.0	86,824.3	15,340.7	85.0
9	Төрийн өмчийн ногдол ашигт	632,894.5	379,736.9	379,736.9	-	100.0
10	Нийт ажиллагсдын тоо	198	271	250	21	92.3
11	Нийт цалингийн сан	7,114,352.8	12,736,606.8	12,369,897.5	366,709.2	97.1
12	Нэг ажиллагчийн дундаж цалин	2,994.3	3,916.5	4,123.3	(206.8)	105.3
	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.9	0.9	0.8	0.1	90.7
14	Хөрөнгө оруулалт / өөрийн хөрөнгөөр	566,586.8	3,386,543.2	2,008,870.8	1,377,672.4	59.3
15	Нийт авлага	219,329.4	2,449,461.5	2,601,925.8	(152,464.4)	106.2
16	Нийт өр төлбөр	18,601,202.3	21,395,000.0	29,655,798.6	(8,260,798.6)	138.6
	Үүнээс: 1. Нормчлолын сангийн бүрдүүлэлттэй холбоотой ХББОСЯ-нд өгөх өглөг	10,591,290.6	16,000,000.0	14,652,351.9	1,347,648.1	91.6
	2. Экспертизийн ажлын хөлсний өглөг	1,394,131.1	1,395,000.0	1,632,308.8	(237,308.8)	117.0
	3. УТХО-той барилгуудын зохиогчид өгөх өглөг болон орон нутгийн ГБХБГ-т өгөх өглөг	4,472,434.3	3,800,000.0	5,485,278.6	(1,685,278.6)	144.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь “Барилгын салбарын хөгжлийг түргэтгэгч, дэмжин туслагч, түншлэгч байгууллага байна” гэж зорилгоо тодорхойлж, барилга байгууламжийн норм, норматив боловсруулах, зураг төсөлд магадлал хийх, техникийн хяналт тавих, сургалт, судалгаа хийх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийн дагуу чиг үүрэг бүхий Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Салбарын хууль, тогтоомж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Барилгын норм норматив, дүрэм, барилгын төсвийн жишиг үнэлгээ, үнийн индекс, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;
- “Барилгын норм, нормативын сангийн хөрөнгөөр боловсруулах норм, норматив, төсөл арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу барилгын норм, дүрмийг боловсруулах ажлыг зохион байгуулах;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;
- Инженер техникийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах;
- Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх баяжилт хөтлөлт хийх, мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Барилга, нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцийн бодлого зорилтыг сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх;
- Салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах;
- Улсын төсөв болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд техникийн хяналт гүйцэтгэх
- Орон сууцны хувьчлал, мэдээллийн санг бүрдүүлэх, иргэд байгууллагуудыг мэдээллээр хангах
- Салбарын бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон судалгаа, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулах
- Барилгын материал, хийц бүтээцийн дээжид сорилт шинжилгээ хийх, дүгнэлт гаргах гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь Монгол улсын Засгийн газрын 2012 оны 47 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар”-ыг татан буулгасантай холбогдуулан барилгын чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий газар болж байгуулагдсан байна.

Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10 “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна.

Энэ хүрээнд 2024 онд хагас жил тутамд үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг явуулж, хандив, үнэ төлбөргүй хүлээн авсан, худалдан авсан хөрөнгийг тухай бүр холбогдох данс бүртгэлд үнэн зөв хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Барилгын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Ахмад настны тухай хуулийн 9.14.9-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь “Ахмадын сан”-гийн үйл ажиллагааны тайлан, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаар жил бүрийн 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор байгууллагын нийт ажилтны хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ”
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
- Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2024 оны “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах” А/52 дугаар тушаал
- Сангийн сайдын 2024 оны А/205 “Журам шинэчлэн батлах тухай” А/205 тушаал

Барилгын хөгжлийн төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар судалж, танилцсан болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс

үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төвийн захирлын 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/89 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,599.3 сая төгрөгөөр буюу 42.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,419,701.2	34,456,517.3	8,036,816.1
Авлага	219,329.4	2,601,925.8	2,382,596.4
Бараа материал	399,104.9	309,698.3	(89,406.6)
Үндсэн хөрөнгө	7,164,957.8	11,434,269.8	4,269,312.1
Нийт хөрөнгө	34,203,093.3	48,802,411.3	14,599,318.0
Өр төлбөр	18,601,202.3	29,655,798.6	11,054,596.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,601,891.1	19,146,612.7	3,544,721.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	34,203,093.3	48,802,411.3	14,599,318.0

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, дансны өглөг, татварын өр, урьдчилж орсон орлого, богино хугацаат бусад өр төлбөр, эздийн өмчийн данстууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 8,036.8 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийсэн, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсний орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 2,382.6 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдэл 219.3 сая төгрөгөөс 203.8 сая төгрөг төлөгдөж, ХХБ-д байршуулсан хөрөнгийн баталгааны авлага 2,450.6 сая төгрөг, ажилчдаас авах гадаад томилолтын 3.8 сая төгрөг, дотоод томилолтын 6.9 сая төгрөг, Петростар ХХК-аас авах 3.6 сая төгрөг, Инвитка солишнс ХХК-аас авах 29.5 сая төгрөг, “Интерактив” ХХК-аас авах 92.0 сая төгрөгийн авлагууд нь тайлант хугацаанд ажил үйлчилгээ, гэрээ хэлцэл бүрэн хэрэгжиж дуусаагүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 309.7 сая төгрөг болж оны эхнээс 89.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 19.3 сая төгрөгийн норм, дүрмийн ном, 192.3 сая төгрөгийн ном сэтгүүл, 184.5 сая төгрөгийн гарын авлага, 339.3 сая төгрөгийн шатах тослох материал, 1,313.9 сая төгрөгийн хангамжийн материал бэлтгэн, 2,138.7 сая төгрөгийг төлөвлөгдсөн зардлын хэмжээнд зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл оны эхнээс 11,434.3 сая төгрөг болж 4,269.3 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 703, 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 223, 2024 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 546 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 29 нэр төрлийн 171 ширхэг нийт 2,428.3 сая төгрөгийн программ хангамж, тоног төхөөрөмж, төвийн сургалтын танхим, 2, 3, 4 дүгээр давхрын өрөөнүүд, байрны гадна фасад узелийн өрөөг засварлаж орлогоор авсан, Хьюндай маркийн Соната суудлын автомашин бүхий хөрөнгө бэлтгэж, ТӨБЗГ-ын даргын 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 207 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд ашиглалтад хүлээлгэн өгсөн, Замын-Үүд хилийн боомтын барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лаборатори байгуулах ажлын хүрээнд бий болсон 50 нэрийн 259 нэр төрлийн нийт 2,917.8 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авснаар нэмэгдсэн.

ТӨБЗГ-ын 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 262 дугаар тогтоолоор 147.2 сая төгрөгийн үнэ бүхий 1 нэрийн 21-71 УНЗ улсын дугаартай Тоёота ланд круйзер 76 авто машиныг Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт балансаас балансад шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2024 оны 282 дугаар тогтоолоор 84 нэр төрлийн 612 ширхэг 1,350.3 сая төгрөгийн балансын үнэ, 1,344.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж, тайлант онд 1,057.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл оны эхнээс 4,269.3 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 546 төсөл арга хэмжээнд барилгуудын зохиогчийн техник хяналт, зургийн зохиогч, экспертизийн ажлын төлбөрүүд нь ажлын гүйцэтгэл бүрэн хангагдаагүйгээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсвийн зохиогчид болон орон нутгийн ГХБХБГ-т техник хяналтын зардалд өгөх 5,195.0 сая төгрөгийг төлөвлөснөөс 7,117.6 сая төгрөгийн өглөг үүсгэсэн, тайлант оны эцэст “Эрдэнэс таван толгой” ХК-аас техник хяналтын зардлын урьдчилгаа 3,500.0 сая төгрөгийн төлбөр орж ирсэн зэрэг нь нийт өр төлбөрийн өссөн үзүүлэлтэд нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 19,146.6 сая төгрөг болж 3,544.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 3,924.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж, ТӨБЗГ-ын 2024 оны 351 дугаар тогтоолоор 379.7 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 703 тоот тогтоолоор Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр нийт орлогыг 15,156.8 сая төгрөг, нийт зардлыг 14,565.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтыг 1,149.0 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 546 тоот тогтоолоор анх батлагдсан нийт орлогыг 13,390.3 сая төгрөг, нийт зардлыг 12,148.5 сая төгрөг, цэвэр ашгийг 1,113.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтыг 2,237.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

Тайлант оны нийт орлогыг 28,547.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 26,714.5 сая төгрөгөөр, 1,644.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 28,959.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 24,577.6 сая төгрөгийн зардал гарган, төлөвлөсөн ашгийг 2,279.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3,924.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 28,959.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 412.3 сая төгрөг буюу 1.4 хувиар давж биелсэн нь зураг төсөл, магадлалын орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 24,577.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,136.9 сая төгрөг буюу 8.0 хувиар дутуу зарцуулж, зардлыг хэмнэж ажилласан байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,386.5 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 18 төсөл, арга хэмжээнд 2,428.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

Мэдээллийн сангийн нэмэлт хөгжүүлэлт, EDOS цахим архив, veritech санхүү, хүний нөөцийн программ, ESTIMATOR PRO 4.0 төсвийн программ хангамж 322.3 сая төгрөг, зөөврийн болон суурин компьютер, скайнер, эйр кондэйшн, өнгөт болон хар принтер, таблет, ухаалаг дэлгэц, гангийн марк болон орц тодорхойлогч, теоделит, үл эвдрэх аргаар бетоны бат бөх тодорхойлогч, бетоны доторх металл, арматурын байрлал, диаметр болон хамгаалалтын үеийн хэмжээг тодорхойлогч багаж, дижитал алх, дром, дулаан хэмжигч скайнер, Examo USB-наалт шалгагч төхөөрөмж, бетоны ан цавын гүн хэмжигч 10-350 мм, тоног төхөөрөмж худалдан авахад 862.8 сая төгрөг, төвийн байрны гадна фасад, 2, 3, 4 давхрын өрөөнүүд болон сургалтын танхимын засвар, дулааны ялтсан бойлер, узелийн болон бусад цахилгаан монтажны засварын ажилд 1,125.1 сая төгрөг, үйлчилгээний зориулалттай суудлын Соната-9 автомашин худалдан авахад 118.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 43,924.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,279.5 сая төгрөгөөр давж биелсэн нь зураг төсөл, магадлалын орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2024 онд 379.7 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээс 379.7 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ТӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Баянжаргал, аудитор Д.Сугар, туслах аудитор Б.Энхчимэг нар гүйцэтгэж, аудитын менежер Ж.Эрдэнэбилэг, захирал Д.Энхбаатар нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав, аудитын менежер В.Эрдэнэцогт, Газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 01/282 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 12,697.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 127.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь сэлбэг, урсгал засварын зардал, зар сурталчилгааны зардал, бичиг хэргийн зардал, ашиглалтын зардлыг хэмнэж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хамаарал бүхий 32 заалтыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 158 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 886,890.2 сая төгрөгийн 158 мэдээллийг бүрэн байршуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах асуудлууд илэрсэн. Үүнд:

1. Тайлант онд нэр бүхий 1 ажилтанд сахилгын шийтгэлийг 2 удаа цалингийн 20.0 хувиар ногдуулсан, дараагийн шатны арга хэжээг аваагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.7 "Сахилгын нэг зөрчилд хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ажилтан, албан хаагчдад сахилын шийтгэлийг ногдуулахдаа компанийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн тухай хуулийг дагуу шат дараалсан арга хэмжээг авах, энэхүү үйлдлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Тус төвийн захирлын А/359 дүгээр тушаалд хөдөлмөрийн дотоод журмын 6.8 дахь хамааралгүй заалтыг үндэслэн үр дүнгийн нэмэгдэл олгох тушаал гаргасан, А/467 дугаар тушаалын хавсралтаар өдрийн хоол төсөвлөхдөө нэгжийн өртгийн нийт дүн 5,642.5 мянган төгрөгөөр төсөвлөсөн, мөн А/647 тушаалаар 22,015.0 мянган төгрөгийн спорт арга хэмжээний өдөрлөгт зориулж хөрөнгийг ерөнхий инженерт захиран зарцуулж, өөрөө хяналт тавьж мөрдүүлэхээр даалгасан зэрэг шийдвэрүүд нь нийцлийн алдаатай байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-д "үр нөлөөтэй байх", 4.2.5 "зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид гаргаж байгаа шийдвэрийн үндэслэлийг үнэн зөв тодорхойлох, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн зарим хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**4.5.1 Завсрын аудитын талаар**

2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар цалин, үндсэн хөрөнгө, төлөгдөөгүй удаж байгаа авлага, барагдуулаагүй өр төлбөрийн нөхцөл байдалтай танилцаж, дотоод хяналтыг үнэлж, жилийн эцсийн аудитын эрсдэлийг тодорхойлж, өмнөх аудитын өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 82.0 сая төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувь биелсэн байна.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	82,023.8	3	82,023.8	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	4	82,023.8	4	82,023.8	100.0

4.5.3 Худалдан авах ажиллагаа

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 2024 онд 1,303.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж, тээврийн хэрэгсэл, 1,125.1 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авсан нь Засгийн газрын 124 дугаар тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”-той нийцэж байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төвийн санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа нормчлолын сангийн дансыг ХББОСЯ-нд шилжүүлэх эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 33,037.2 сая төгрөгийн алдааг¹ залруулсан.

Залруулсан алдаа:

- 2024 оны санхүү байдлын тайлангийн эргэлтийн бус хөрөнгийн дансны эхний үлдэгдлийг 901.0 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Санхүүгийн тайлангийн авлага, өглөгийн тодруулга тайланд 32,136.2 сая төгрөгийг буруу тайлагнасан байна.

Энэ нь НББОУС 1.15 "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг Үзэл баримтлал 3-д заасан хөрөнгө өр төлбөр, орлого зарлагын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 14.0 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, алдаа зөрчлийг арилгах 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 14.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт:

Тус төвийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 15 өдрийн Б/349 дүгээр тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгосон бөгөөд мөн төвийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/418 тушаалаар Чингэлтэй дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу 5.5 сая төгрөгийн тэтгэмжийг дахин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 "Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Тус төвийн захирлын 2024 оны А/483 тушаалаар үе үеийн удирдлагуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 8.4 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага өгөв.

Дээрх зөрчлийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын залруулсан алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын залруулсан алдааны нэгтгэл												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын 2024 оны санхүү байдлын тайлангийн эргэлтийн бус хөрөнгийн дансны эхний үлдэгдлийг 900,977.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	900,977.3			1	900,977.3	1	900,977.3				
Санхүүгийн тайлангийн авлагын тодруулгын тайланд 2,480,425.8 мянган төгрөгийн авлагыг 5 жилээс дээш насжилттай тооцоо нийлээгүй авлага гэж буруу тайлагнасан.	1	2,480,425.8			1	2,480,425.8	1	2,480,425.8				
Санхүүгийн тайлангийн өглөгийн тодруулгын тайланд 29,655,798.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өглөг гэж буруу тайлагнасан.	1	29,655,798.6			1	29,655,798.6	1	29,655,798.6				
Дүн	3	33,037,201.7			3	33,037,201.7	3	33,037,201.7				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Үүнээс										/мянган төгрөгөөр/	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус төвийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 15 өдрийн Б/349 дүгээр тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгосон бөгөөд мөн төвийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/418 тушаалаар Чингэлтэй дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу 5,526.9 мянган төгрөгийн тэтгэмжийг дахин олгосон байна.	1	5,526.9	1	5,526.9								
Тус төвийн захирлын 2024 оны А/483 тушаалаар үе үеийн удирдлагуудад хүндэтгэл үзүүлж, 8,434.3 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.	1	8,434.3			1	8,434.3						
Дүн	2	13,961.2	1	5,526.9	1	8,434.3						

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тайлант онд нэр бүхий 1 ажилтанд сахилгын шийтгэлийг 2 удаа цалингийн 20.0 хувиар ногдуулсан, дараагийн шатны арга хэжээг аваагүй байна.	1	-			1	-
Тус төвийн захирлын А/359 дүгээр тушаалд хөдөлмөрийн дотоод журмын хамааралгүй 6.8 дахь заалтыг үндэслэн үр дүнгийн нэмэгдэл олгох тушаал гаргасан, А/467 дугаар тушаалын хавсралтаар өдрийн хоол төсөвлөхдөө нэгжийн өртгийн нийт дүн 5,642.5 мянган төгрөгөөр төсөвлөсөн, мөн А/647 тушаалаар 22,015.0 мянган төгрөгийн спорт арга хэмжээний өдөрлөгт зориулж хөрөнгийг ерөнхий инженерт захиран зарцуулж, өөрөө хяналт тавьж мөрдүүлэхээр даалгасан зэрэг шийдвэрүүд нь нийцлийн алдаатай байна.	1	27,657.5			1	27,657.5
Дүн	2	27,657.5			2	27,657.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 03 дугаар сарын 14 № 149/00150185
СНАГ-2025/044/НА-СТА-704Г

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 15 өдрийн Б/349 дүгээр тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгосон бөгөөд мөн төвийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/418 тушаалаар Чингэлтэй дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу 5,526,900.00 /таван сая таван зуун хорин зургаан мянга есөн зуун/ төгрөгийн тэтгэмжийг дахин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 "Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/05 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүсэв" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд нэг удаагийн тэтгэмж олгохдоо давхардуулан 5,526,900.00 /таван сая таван зуун хорин зургаан мянга есөн зуун/ төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Т.Пүрэвхатан/, Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Ц.Бат-Өлзий/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГ
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 533/20/SC/85

Улаанбаатар хот

СНМТ-2025/04/НА-СТА-ТӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирлын 2024 оны А/483 тушаалаар үе үеийн удирдлагуудад хүндэтгэл үзүүлж, 8,434,255 00 /найман сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга хоёр зуун тавин таван/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Т.Пүрэвхатан/, Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Ц.Бат-Өлзий/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ийн
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Д.ЭНХБААТАР